

Эрдэм шинжилгээний өгүүлэл
УДК 303.4
DOI: 10.18101/2949-1657-2023-4-26-40

**СОЦИОЛОГИЙН СУДАЛГААНД ТУЛГУУРЛАН ЛОГИСТИК
МЕНЕЖМЕНТ ХӨТӨЛБӨРИЙГ БОЛОВСРУУЛАХ ЗАРИМ АСУУДАЛ**

© **Үржинсүрэн Жаргал**
доктор (PhD)
urjinsuren@num.edu.mn

© **Болормаа Жамбаа**
магистр (МВА)
Bolormaa.j@num.edu.mn

© **Хонгорзул Даваа**
доктор (PhD)
Khongorzul_d@num.edu.mn

© **Сарантуяа Баатар**
магистр (МВА)
Sarantuya.b@num.edu.mn

© **Мөнхбат Норовжамц**
магистр (МВА)
munkhbat.n@num.edu.mn

© **Бат-Орших Алтангэрэл**
магистр (МВА)
Batorshikh.a@num.edu.mn

Монгол Улсын Их Сургууль
Их сургуулийн гудамж-1, бага тойруу, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот

Хураангуй. Монгол Улсын хөгжлийн бодлого, алсын хараа 2050 хөтөлбөрийн «Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, дундаж давхарга зонхилсон, ядуурал эрс буурсан, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, дотоод хэрэгцээгээ өөрсдөө хангадаг, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа бүрдүүлсэн, олон тулгуурт эдийн засагтай улс болно» (УИХ, 2020) гэсэн зорилгын хүрээнд чадварлаг менежерүүдийг шинжлэх ухаанч сэтгэлгээ, өөрийгөө хөгжүүлэх чадвар, харилцааны өндөр соёлтой, шинжлэх ухаан, үйлдвэрлэл, технологи, тээвэр, нийгмийн салбарт бие даан ажиллах мэдлэг чадвар эзэмшүүлэх, судлаач мэргэжилтнийг хувь хүний авьяас сонирхол, нийгмийн хэрэгцээ, дэлхийн хөгжилтэй орнуудын жишиг хандлагад нийцүүлэн бэлтгэн гаргах хэрэгцээ шаардлагын үндсэн дээр уг мэргэжлийн хөтөлбөрийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон болно.

Түлхүүр үг: логистик, тээврийн салбар, эдийн засаг, олон улсын тээвэр, эрэлт хэрэгцээ.

Ишлэл

Социологийн судалгаанд тулгуурлан логистик менежмент хөтөлбөрийг боловсруулах зарим асуудал / У. Жаргал, Ж. Болормаа, Д. Хонгорзул [бусад] // Зүүн зүгийн вектор: түүх, нийгэм, улс. 2023; 4: (Орос хэл дээр). Х. 26–40.

Удиртгал

Далайд гарцгүй Монгол орны эдийн засгийн өсөлтийн гол түлхүүр нь тээврийн салбар юм. Тээврийн салбар үүсэж хөгжсөнөөс хойш Монгол Улсын тээврийн тогтолцоог судалж үзэхэд тээврийн төрлүүдэд автозам, төмөр зам, агаар болон усан замын үндсэн 4 төрлийн тээврийн дэд салбарууд үйл ажиллагаа явуулж байна.

Бүх төрлийн тээврийн орлого 2022 оны эхний 9 сард 1.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 342.7 (33.4%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Энэхүү өсөлтөд агаарын тээврийн орлого 211.6 (2.8 дахин) тэрбум төгрөг, авто замын тээврийн орлого 204.8 (65.5%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлсөн байна. Бүх төрлийн тээврийн орлого 2022 оны 3 дугаар улиралд өмнөх улирлаас 151.9 (33.2%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

2021 оны байдлаар тээвэр логистиктой холбоотой 1694 компани бүртгэгдсэн байна. Энэ нь зам тээврийн салбарын нийт компанийн 77%-ийг, агуулахын салбар 20%-ийг, хамтдаа зам тээвэр агуулахын салбарын 97%-ийг бүрдүүлж байна. (Mongolia K. , 2021, хууд. 13)

Өнөөдрийн байдлаар Монгол улсын хэмжээнд бакалаврын түвшинд логистик менежмент сургалтын хөтөлбөрийг 3 их дээд сургууль хэрэгжүүлж байна. Үүнээс төрийн өмчит 2, хувийн хэвшлийн нэг их сургууль байна. Тухайлбал төрийн өмчит «Шинжлэх ухаан технологийн, Механик тээврийн их сургууль, УБТЗ дээд сургууль, хувийн хэвшлийн «Мандах их сургууль» тус тус үйл ажиллагаа явуулж байгаа юм.

Хөтөлбөрийн бодлогын баримт бичигт туссан байдал

Логистик менежмент хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигт шүүж үзвэл, Засгийн газрын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт холбогдох 1 заалт, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд холбогдох 2 заалт, «Алсын хараа-2050» Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогод холбогдох 6 заалт орсон байна. Тэр тусмаа «Алсын хараа-2050» бодлогын баримт бичигт холбогдох 5 заалт, шинэ сэргэлтийн бодлогод холбогдох 3 заалт орсон байна. Ялангуяа «Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд Монгол улсын хөгжлийг хязгаарлаж буй зургаан багц асуудлын нэгт боомтын сэргэлтийн асуудалд логистик, тээвэртэй холбоотой хэрэгжүүлэх ажлууд чухлаар тавигдсан байна.

Монгол Улсын хууль тогтоомжид тээвэр, бараа бүтээгдэхүүний агуулах, тээврийн нэгдсэн логистикийн сүлжээний асуудлыг хэрхэн зохицуулсан талаарх зүйл заалтууд ерөнхий байдлаар тусгагдсан байна.

Хүснэгт 1

Логистикийн талаарх асуудал монгол улсын хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан байдал

№	Баримт бичгийн нэр	Логистиктой холбогдох заалт (үялдаа холбоо)
1	Засгийн газрын 2016–2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр	«Эдийн засгийн өсөлтийг дэмжсэн, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн аюулгүй, ая тухтай үйлчилгээ үзүүлэх зам, тээвэр, логистикийн сүлжээг өргөжүүлэн хөгжүүлэх» гэсэн зорилтыг тусгасан.
2	Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	Олон улсын чанартай тээвэр, логистикийн төвүүдийг байгуулсан байна. (4.2.9) Агаарын тээврийн либералчлалыг хэрэгжүүлж, нислэгийн чиглэл, тоог нэмэгдүүлсэн байна. (4.2.10)
3	Алсын хараа 2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого	Хөдөө аж ахуй, тээвэр логистик, төрөлжсөн аялал жуулчлалын салбарыг бүс, орон нутгийн хөгжлийг дэмжих замаар хөгжүүлнэ. (4.2.2) Бараа, үйлчилгээг худалдах, тээвэрлэх, хянах, хөрөнгө оруулах, зах зээлд нэвтрэх нөхцөлүүдийг ил тод болгох, бүртгэл ба мэдээллийн нэгдсэн системийг бий болгох, цаасгүй технологи нэвтрүүлэх, эрсдэлд 22 / 48 суурилсан удирдлага ба хяналтыг» бий болгоно. (4.4.2) «Эдийн засгийн коридор бий болгох гурван талт хэлэлцээрийг боловсронгуй болгож, Монгол Улс тээвэр, логистик, хот байгуулалт, хил дамнанас худалдаа, аялал жуулчлалын дэд бүтцийн бүтээн байгуулалтын» төслийг хэрэгжүүлнэ. (4.4.4) «Олон улсын агаарын карго тээврийн логистикийн төв байгуулж, ачааны төвлөрөл» бий болгоно. (4.4.6) Олон улсын тээвэр логистикийн 3, бүсийн тээвэр логистикийн 6, орон нутгийн тээвэр, логистикийн 33 төвийг тус тус барина хэмээн тодорхойлсноор эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгохоор тусгажээ. (8.1.4)
4	Шинэ сэргэлтийн бодлого	Боомтуудын хатуу, зөөлөн дэд бүтцийг хөгжүүлэн ачаа болон зорчигч нэвтрүүлэх хүчин чадлыг дээшлүүлж, экспортыг нэмэгдүүлнэ (1.1) Хилийн боомтуудыг төмөр зам болон хатуу хучилттай авто замаар үе шаттайгаар бүрэн холбон, тээвэр, логистикийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн ачаа тээврийн урсгалыг сайжруулж, цашид транзит улс болох суурь нөхцөлийг бүрдүүлнэ. (1.2) Монгол Улсын агаарын зайн зохион байгуулалт, агаарын замын ашиглалтыг сайжруулан дамжин өнгөрөх агаарын хөлгийн тоог нэмэгдүүлж, агаарын тээврийн либералчлалыг үе шаттайгаар үргэлжлүүлэх замаар ачаа тээврийн зангилаа төвийг бий болгож, мөн аялал жуулчлалын салбарыг дэмжинэ. (1.3)

Логистикийн тухай ойлголт нь нийгмийн бүхий л салбарыг хамарсан, маш өргөн цар хүрээтэй, эдийн засгийн бүхий л оролцогчдод хүрч үйлчилдэг салбар юм. Иймээс логистиктой холбогдох хууль, эрх зүйн орчин нь нэлээн өргөн хүрээнд үйлчилж байна. Тухайлбал: Зам Тээврийн Хөгжлийн Яамны алсын хараа, эрхэм зорилго зорилтод тээвэр логистикийн асуудлыг анхааран авч үзэн дараах байдлаар тусгажээ.

Эрхэм зорилгод Монгол Улс Ази европыг холбосон эдийн засгийн өсөлтийг хангах, экспортыг нэмэгдүүлэх зам тээврийн сүлжээг өргөжүүлэх, байгаль орчинд ээлтэй, эрэлтэд нийцсэн тогтвортой, хүртээмжтэй, аюулгүй тээврийн үйлчилгээг хөгжүүлэх тээвэр логистикийн зангилаа төв болно (Legalinfo.mn, 2020).

Мөн авто замын тухай хууль, агаарын зайг нисэхэд ашиглах тухай хууль, байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, гаалийн тухай хууль, инновацийн тухай, өрсөлдөөний тухай хууль, төмөр замын тээврийн тухай хууль, усан замын тээврийн тухай хууль, улсын нисэхийн тухай хууль, хүнсний тухай хууль, хот байгуулалтын тухай хууль зэрэг хууль тогтоомжуудад тээвэр зуучлал, логистикийн үйл ажиллагааг тусгасан байна.

Логистикийн салбарын тухай суурь бие даасан хууль байхгүй, логистикийн үйлчилгээг өндөр түвшинд хүргэх, логистикийн байгууламжийг барихтай холбогдох тусдаа хууль байхгүй байна. Тээврийн хэлбэр тус бүрээр дэд бүтцийг бүтээн байгуулах болон үйлчилгээг удирдахад төвлөрсөн хуулиуд байна.

Олон улсын туршлага

Логистикийн талаарх олон тодорхойлолт байдаг бөгөөд хамгийн чухал гэж үздэг олон улсын нэр бүхий байгууллагуудын тодорхойлолтыг танилцуулбал:

International Institute Applied Systems Analyses (IIASA) 1986: «Логистик гэдэг нь хэрэгцээт барааг аль болох бага зардлаар бий болгон хэрэглэгчдэд хүргэх бүх үйл ажиллагааны нийлбэр юм. Өөрөөр хэлбэл түүхий эд нийлүүлэлт, хадгалалтаас эхлээд үйлдвэрлэлийн технологийн үйлдлүүдийн хооронд явагдах хагас бэлэн бүтээгдэхүүнийг зөөвөрлөх, баглах боох, бэлэн бүтээгдэхүүн хадгалах, хэрэглэгчдэд хүргэх бүх үйл ажиллагаа» хэмээсэн байдаг

European Logistics Association (ELA) 1991: «Шинэ бүтээгдэхүүний төлөвлөлт, түүхий эд худалдан авахаас эхэлж хэрэглэгчийн захиалгад нийцүүлэн үйлдвэрлэн нийлүүлэх бүх үйл ажиллагааг хамгийн бага зардал, хөрөнгө гарган хэрэглэгчийн бүх шаардлагыг хангасан байхаар зохион байгуулах, төлөвлөн удирдахыг хэлнэ» гэсэн байдаг.

Institute of Logistics 1995 England: «Логистик нь хүн хүч, материал, үйлдвэрийн хүчин чадал, мэдээллийг ашиглан хэрэгтэй үед нь хэрэгцээт хэмжээгээр үйлдвэрлэн, шаардлага хангасан чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээг тохирсон үнэ хүргэн зохистой газарт нь борлуулахад оршино» хэмээжээ.

Тэгвэл Логистик гэх энэ үгний тодорхойлолтыг энгийнээр тайлбарлавал:

Логистик гэдэг нь хэрэгцээт барааг аль болох бага зардлаар бий болгон хэрэглэгчдэд хүргэх бүх үйл ажиллагааг хэлдэг. Нэг үгээр хэлбэл бараа бүтээгдэхүүний гарал үүслээс хэрэглээний цэг хүртэл үр ашигтай тээвэрлэлт, хадгалалт, төлөвлөлт, гүйцэтгэл, хяналтын нэгдмэл процессыг хэрэгжүүлэх үйл явц юм. Логистикийн гол зорилго нь хэрэглэгчийн шаардлагыг цаг тухайд нь, үр ашигтай өгөх хэлбэр бөгөөд, зах зээлийн нийгэмд логистикийн салбар нь маш өргөн цар хүрээг хамарсан, эдийн засгийн бүхий л оролцогчдод хүрч үйлчилдэг амин чухал салбар яах ч аргагүй мөн билээ (ХХК, 2019).

Олон улс дахь логистикийн сургалтын хөтөлбөр

MIT CTL (Center for Transportation and Logistics) (Techology, 2021)

1. MIT CTL-д SCM магистр-докторын зэргийн сургалт, микро магистрын хөтөлбөр (онлайн), GCLOG(Graduate Certificate in Logistics & Supply Chain Management, Латин Америк, Карибын тэнгисийн орнуудад магистрын зэрэгтэй

оюутнуудад зориулсан богино хугацааны магистрын хөтөлбөр), менежер (Executive Education), SC Bootcamp(богино хугацааны сургалт зэргийг зохион байгуулж байна.

2. Магистрын сургалтыг (MIT SCALE) АНУ-аас гадна Испани (MIT-Zaragoza), Люксембург (MIT-Luxembourg), Хятад (MIT-Ningbo), Малайз (MIT-Malaysia) зэрэг MIT Global SCALE Network 5 газрын сургалтын байгууллага (Их сургууль)-тай хамтран хийж байна. (dual –masters)

3. 5 газрын MIT Global SCALE Networks-ийн магистрын хөтөлбөрт суралцаж буй оюутнууд өвлийн улирлын турш АНУ-ын үндсэн их сургуульд гурван долоо хоногийн семинар, Python, машин сурах гэх мэт сургалтуудад хамрагдаж, үлдсэн хугацаанд төв тус бүртээ боловсрол эзэмшдэг

TLI-AP (The Logistics Institute– Asia Pacific) (Singapore, 2023)

1. Сингапурын TLI-AP нь Сингапурын Үндэсний Их Сургууль (NUS), Жоржиагийн Технологийн Институтээс (Georgia Institute of Technology) хамтран дэлхийн логистикийн судалгаа, боловсролын чиглэлээр байгуулагдсан хамтын ажиллагааны боловсролын байгууллага юм.

2. TLI-AP нь Сингапурын Эдийн Засгийн Хөгжлийн Зөвлөл (EDB), Шинжлэх ухаан, технологийн агентлаг (A * STAR) зэрэг томоохон байгууллагуудын дэмжлэгийг авч, үүгээр дамжуулан ажиллах хүчнээ хөгжүүлэх сургалтын хөтөлбөрөөр хангаж, шинэ технологийг ашиглан логистикийн шинэлэг шийдлүүдийг дэмжиж ажилладаг.

3. Нийлүүлэлтийн сүлжээний менежментийн шинжлэх ухааны магистр (SCM), Глобал логистик ба хангамжийн сүлжээний нэгдсэн судалгааны хөтөлбөр, Think цуврал хөтөлбөр (2 форум ба форумын хүрээнд богино хугацааны семинаруудаас бүрдэнэ) гэсэн 3 хөтөлбөр хэрэгжүүлж байна.

SCM магистрын хөтөлбөр

1. 2011 оноос эхэлсэн SCM магистрын хөтөлбөр нь логистикийн чиглэлээр туршлагатай хүмүүст тохиромжтой бөгөөд, NUS ба АНУ, Жоржиагийн технологийн сургуульд магистрын зэрэг олгодог.

2. TLI-AP, NUS Industrial Engineering (ISEM) болон бизнесийн сургууль (DAO) -ын профессоруудад тулгуурлан явагдаж байгаа бөгөөд Сингапурын томоохон байгууллагуудын ажилтнууд нэмэлт эсвэл тусгай хэлбэрээр лекц уншдаг.

3. Төгсөлтийн шаардлагад үндсэн 3 курс, 5 сонгон хичээл, салбар дээр суурилсан төслүүд (судлаачид ба үйлдвэрлэлийн хооронд ганцаарчилсан сургалт) багтаж, бүтэн цагийн хөтөлбөр нь 1 ба 2 жилийн, хагас цагийн хөтөлбөр нь 2 ба 4 жилийн сургалтаас бүрдэнэ.

Think цуврал хөтөлбөр

1. Think цуврал нь салбарын удирдагчид, нийлүүлэлтийн сүлжээний мэргэжилтнүүд ба эрдэм шинжилгээний байгууллагуудыг нэгтгэдэг.

2. Логистикийн салбарын орчныг бүрдүүлж буй шинэ сорилт, технологи, ур чадварыг шийдвэрлэхийн тулд сэтгэн бодох манлайллын байршил \positioning\ мэдлэгийг түгээх ба менежментийн сургалтад хамрагдах платформ юм.

3. Think цувралд 4-5 хоног үргэлжлэх Think logistics болон Think Solutions гэсэн хоёр форум, Think Tables, Think (work) Shops, Logistics Executive богино хугацааны семинар зэрэг багтсан болно (Mongolia 2. К., 2020).

Судалгааны үр дүн

Санал асуулгын судалгаанд Мандах их сургууль, УБТЗ-ын дээд сургууль, ШУТИС-ын Механик тээврийн их сургуулиудын логистик менежмент, тээвэрлэлтийн мэргэжлийн нийт 200 оюутан хамрагдсан. Санал асуулгын судалгаагаар тухайн хөтөлбөрөөр (ойролцоо мэргэжил) бусад сургуульд сурч буй оюутнуудын сэтгэл ханамж, нөхцөл байдал, эрэлт хэрэгцээ, сургалтын нөхцөл байдлын хүлээлт, суралцах зан үйл зэргийг тандан судлав.

Хүснэгт 2

Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл
(Логистик менежмент хөтөлбөр)

№	Утга	Тооллолт	Хувь
Таны нас			
1	17 настай	2	1.0
2	18 настай	54	27.3
3	19 настай	44	22.2
4	20 настай	40	20.2
5	21 настай	18	9.1
6	22 настай	30	15.2
7	23-аас дээш настай	12	5.1
Таны хүйс			
1	Эрэгтэй	132	66.7
2	Эмэгтэй	68	33.3
Та хэддүгээр түвшинд суралцаж байна вэ?			
1	1-р түвшин	82	41.4
2	2-р түвшин	36	18.2
3	3-р түвшин	32	16.2
4	4-р түвшин	48	24.2
Таны суралцаж буй сургууль			
1	Мандах Их сургууль	46	23.2
2	УБТЗДС	92	46.4
3	ШУТИС (МТИС)	60	30.4
Та ямар мэргэжлээр суралцаж байна вэ?			
1	Логистик менежмент	106	53.5
2	Тээвэрлэлт	94	46.5
Нийт		200	100

Санал асуулгын судалгаанд нийт 3 сургуулийн 200 оюутан хамрагдсан бөгөөд тэдний 132 нь 66.7 хувь эрэгтэй, 68 нь буюу 33.3 хувь эмэгтэй байв. Насны хувьд 70 орчим хувь нь 18-20 настай, үлдсэн 30 хувь нь 21-ээс дээш настай оюутнууд хамрагдав


Хөтөлбөрийн эрэлт хэрэгцээ

«Логистик менежмент» хөтөлбөрийн эрэлт хэрэгцээг асуумжийн судалгаанд оролцсон оюутнууд болон ярилцлагын судалгаанд оролцсон экспертүүдийн хувьд сүүлийн үед хөгжиж байгаа салбар учраас ерөнхийдөө маш хэрэгцээтэй гэж дүгнэж байна.

Учир нь энэ чиглэлээр мөн ойролцоо мэргэжлээр сурдаг оюутнууд өөрийн мэргэжилдээ 1-рт сэтгэл ханамж өндөртэй (График 8), 2-рт энэ чиглэлээрээ ажлын байран дээр гараад ажиллана гэж 66.7 хувь нь үзсэн байна. (График 9) Мөн ярилцлагын судалгаанд оролцсон оролцогчид өнөө цаг үеийн эрчимтэй хөгжиж байгаа логистикийн асуудлын талаар ярих цаг болсон бөгөөд төрийн нэгдсэн бодлого, уялдаа холбоо дэмжлэг маш чухал хэрэгтэй байна мөн энэ чиглэлээр хангалттай сайн боловсон хүчин хүний нөөц, бэлтгэх сургалтын орчин хэрэгтэй байна хэмээх санал бодлоо хуваалцлаа.

График 1

Та одоо суралцаж буй мэргэжил (хөтөлбөр)-дээ хэр зэрэг сэтгэл хангалттай байна вэ?




Судалгаанд оролцсон 3 сургуулийн логистик менежмент, тээвэрлэлтийн хөтөлбөрөөр сурдаг оюутнуудаас Мандах их сургуулийн оюутнууд болон УБТЗ-ын дээд сургуулийн оюутнууд тухайн хөтөлбөртөө хамгийн их сэтгэл ханамжтай

байдаг бол ШУТИС-МТИС-ийн оюутнууд хамгийн бага үзүүлэлтэй байна. Харин хөтөлбөрийн хэмжээнд нийт сургуулийн оюутнуудын дундаж нь 94 хувь нь ер нь сэтгэл ханамжтай гэсэн үзүүлэлттэй гарсан байна.

График 2


Логистик менежмент хөтөлбөр Монгол улсын хөгжил, алсын хараатай хэр зэрэг уялдаатай гэж бодож байна вэ?



Судалгаанд оролцсон оюутнууд логистик менежмент хөтөлбөрийг Монгол Улсын хөгжил, алсын хараатай уялдаатай байдлыг 38.4 хувь нь маш чухал уялдаатай, мөн 51.5 хувь нь ер нь уялдаатай гэж хариулжээ. Харин дам байдлаар уялдана гэж 10.1 хувь нь үзсэн байна.

График 3


Логистик менежмент мэргэжлээрээ ахисан түвшин (магистр, доктор)-д суралцах уу?



Судалгаанд хамрагдсан оюутнууд Логистик менежмент хөтөлбөрөөр цаашид ахисан түвшинд буюу магистр болон докторын сургалтад 50 орчим хувь нь суралцахгүй гэж хариулсан бол 21 хувь нь суралцана гэж хариулсан байна. Мөн одоогоор суралцах эсэхээ шийдээгүй мэдэхгүй байгаа оюутнууд 1\3 нь байна.

График 4

Та их сургууль төгсөөд одоо суралцаж буй (Логистик менежмент) мэргэжлээрээ ажиллах эсэх




Судалгаанд хамрагдсан оюутнуудаас одоогийн эзэмшиж буй логистик менежмент, мэргэжлээрээ ажлын байран дээр гараад ажиллах эсэхийг тодруулахад тэдний 66.7 хувь нь тийм гэж хариулсан. Мөн 17.2 хувь нь оролдоод үзнэ хэмээн хариулсан байна.

Хөтөлбөрийн алсын хараа, зах зээлийн өрсөлдөөн

Хөтөлбөр нь Монгол Улсын хөгжил, алсын хараатай уялдах байдал, хөдөлмөрийн зах зээлийн өрсөлдөөн ямар байх талаар судалгаанд оролцогчид Монгол Улсын хөгжил, алсын ерөнхийдөө уялдаж байна гэж 90 орчим хувь нь үзсэн байна. (График №2), Мөн ярилцлагын судалгааны оролцогчид логистикийн хөтөлбөрөөр төгсөгчид ажлын байрны эрэлт хэрэгцээ өндөр байгаа талаар ярилцлагадаа дурдсан.

График 5

Логистик менежмент мэргэжил зах зээлд хэр зэрэг эрэлт, хэрэгцээтэй байдлыг үнэлэж байгаа байдал



Судалгаанд хамрагдсан оюутнууд логистик менежмент мэргэжил зах зээлд эрэлт, хэрэгцээтэй байдлыг маш их гэж 28.3 хувь нь ер нь эрэлттэй гэж 58.6 хувь


нь дунд зэрэг гэж 11.1 хувь нь эрэлт багатай гэж 2 хувь нь үнээс харвал 87 орчим хувь нь энэ мэргэжлийг эрэлт хэрэгцээ өндөртэй гэж үзжээ.

Сургалтын нөхцөл байдлын эрэлт, хэрэгцээ

Логистик хөтөлбөрийг хэрэгжүүлэх, бусад сургууль энэ чиглэлээр шаардлагатай цогц чадамжийг хэр зэрэг олгож байгаа талаар, орчин үеийн их, дээд сургуулийн ахисан түвшний сургалтын шинэ хандлагын талаар, материаллаг бааз, хүний нөөцийн талаар судалгаанд оролцсон оролцогчид дараах байдлаар үзэж байна.

График 6


Сургуулийн зүгээс таны суралцаж буй мэргэжлээр шаардлагатай мэргэжлийн цогц чадамжийг хэр зэрэг олгож байна вэ?



Судалгаанд хамрагдсан сургуулийн оюутнууд тус хөтөлбөрт шаардлагатай мэргэжлийн цогц чадамжийг олгож чадаж байгаа эсэх дээр Мандах их сургууль болон УБТЗ-ын дээд сургуулийн оюутнууд өндрөөр үнэлсэн байна. Харин ШУТИС (МХТС)-ийн оюутнууд тааруу гэж өөрсдийгөө үнэлсэн байна. Нийт сургуулиудын дунджийг авч үзвэл маш сайн гэж 23.2 хувь нь сайн гэж 55.6 хувь нь дунд гэж 12.1 хувь нь үлдсэн 9.1 мэдэхгүй гэж үнэлсэн байна.

График 7

Логистик менежмент мэргэжлээр магистрын хөтөлбөр нээвэл та хэр зэрэг сонирхох вэ?



Логистик менежмент хөтөлбөрөөр магистрын хөтөлбөр нээвэл судалгаанд хамрагдсан оюутнуудын 43.4 хувь нь маш их сонирхоно, 31.3 ерөнхийдөө сонирхоно, 10.1 хувь нь дунд зэрэг, сонирхохгүй, огт сонирхолгүй гэж хариулсан нь тус тус 2 хувь, 11.1 хувь нь мэдэхгүй гэж харилжээ

Сургалтын нөхцөл байдлын эрэлт, хэрэгцээ

Хүснэгт 8

Ахисан түвшний магистрын хөтөлбөрт сургалтын орчин, материаллаг бааз, хүний нөөц, хичээлийн агууллагын дараах хүчин зүйлсээс үнэлж байгаа байдал

№	Хүчин зүйлс	Огт чухал биш	Чухал биш	Дунд	Чухал	Маш чухал	Мэдэхгүй
1	Бие даан хөгжих орчин	1%	8.1%	10.1%	55.6%	25.2%	0%
2	Сайн дурын болон чөлөөт цагаа өнгөрөөх боломж	0%	9.2%	12.2%	51%	27.6%	0%
3	Эрдэм шинжилгээний ажил хийх боломж	5.1%	4%	5.1%	52.5%	33.3%	0%
4	Номын сангийн үйлчилгээ	2%	7.1%	7.1	45.5	38.4%	0%
5	Ариун цэврийн өрөөний нөхцөл	2%	8.1%	29.3%	30.3%	30.3%	0%
6	Сургуулийн байр, байгууламж	1%	8.1%	1%	48.5%	41.4%	0%
7	Сургалтын анги, танхим	1%	8.1%	2%	46.5%	42.4%	0%
8	Сургуулийн дотуур байр	0%	10.1%	14.1%	40.4%	33.3%	0%
9	Сургалтын лаборатори (төрөлжсөн)	0%	9.1%	2%	21.2%	65.7%	0%
10	Хамтын ажиллагаа (Дотоод болон ОУ-ын их)	3%	6.1%	2%	34.4%	49.5%	0%

У. Жаргал, Ж. Болормаа, Д. Хонгорзул бусад. Социологийн судалгаанд тулгуурлан логистик менежмент хөтөлбөрийг боловсруулах зарим асуудал


	дээд сургуулиуд, төрийн, ТББ-тай хамтран ажилладаг байх)						
11	Төрөл бүрийн тэтгэлэг, тэтгэмж, солилцооны хөтөлбөрт хамрагдах боломжтой байх	4%	5.1%	1%	34.3%	55.6%	0%
12	Магистрант оюутан бусад судлаач болон багш нартайгаа хамтран судалгааны ажил хийх	3%	6.1%	2%	39.4%	49.5%	0%
13	Багшийн хүрэлцээ, чанар		5.1%	5.1%	22.2%	66.7%	1%
14	Ажилтнуудын хүрэлцээ, чанар		6.1%	5.1%	32.3%	55.6%	1%
15	Хөтөлбөрийн боловсролын зорилго, суралцахуйн үр дүн	4%	5.1%	4%	17.2%	69.7%	0%
16	Сургалтын төлөвлөгөө	4%	5.1%	2%	25.3%	63.6%	0%
17	Хичээл, хичээлийн хөтөлбөр	4%	5.1%	3%	17.2%	70.7%	0%

Судалгаанд хамрагдсан оюутнуудаас ахисан түвшний магистрын хөтөлбөрт сургалтын дээрх орчин, материаллаг бааз, хүний нөөц, хичээлийн агуулгын хүчин зүйлүүдээс хамгийн чухал аль болохыг тандахад:

- Сургуулийн байр, байгууламж
- Төрөл бүрийн тэтгэлэг, тэтгэмж, солилцооны хөтөлбөрт хамрагдах боломжтой байх
- Сургалтын төлөвлөгөө
- Магистрант оюутан бусад судлаач болон багш нартайгаа хамтран судалгааны ажил хийх
- Багшийн хүрэлцээ, чанар зэрэг хүчин зүйлс хамгийн чухлаар хөндөгджээ.

График 9

Сургалтыг танхим болон цахим сургалтын ялгаатай байдал



Судалгаанд хамрагдсан оюутнуудаас сургалтыг цахимаар болон танхимаар явуулах нь ямар ялгаатай болохыг тодруулахад ялгаатай танхимын сургалт илүү гэж 67.7 хувь нь үзсэн бол онлайн сургалтыг илүү гэж 4 хувь нь үзжээ. Мөн ялгаагүй, ижил үр дүнтэй гэж 12.1 хувь нь үзжээ. Харин аль алинд давуу болон сул тал байдаг хослуулах хэрэгтэй гэж 16.2 хувь нь үзсэн байна.

Логистик менежмент хөтөлбөрийн хүрээнд илүү нарийвчлан судлах ёстой сэдвийг судалгаанд хамрагдсан оюутнууд дараах байдлаар томъёолсон байна. Үүнд:

- Агуулах үйл ажиллагаа
- Борлуулалт
- Нийлүүлэлтийн менежмент
- Ногоон логистик
- Тээвэрлэлт
- Үйлдвэрлэх логистик
- Экспорт

Мөн ярилцлагын судалгаанд хамрагдсан экспертүүд дараах байдлаар хөтөлбөрийн хүрээнд нарийвчлан судлах ёстой сэдвийг авч үзэж байна.

Дүгнэлт

Манай улсад логистикийн 1700 орчим компани бүртгэлтэй бөгөөд 77 хувь нь зам тээврийн салбар, 20 хувь нь агуулахын салбарт үйл ажиллагаа явуулж байна. «Ковид-19» цар тахлын үр дагаварт гэнэтийн зогсонги байдалд орсон боловч энэ салбар сүүлийн жилүүдэд эрчимтэй өсөж байна. Сүүлийн 30 жилд шинэ тутамд хөгжиж байгаа боловч бүхэлдээ өндөр өсөлттэй, дэлхий нийтийн хөгжлийн жишигт нийцүүлэх шаардлагатай, нөгөө талаас Монгол Улсын хөгжлийн тэргүүлэх чиглэл болж байгаа чиглэл мөн.

Нийгэм эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх чиглэл болох хувьдаа Монгол Улсын дунд болон урт хугацааны бодлогод тэргүүлэх чиглэл болж тусгагджээ. Тухайлбал, «Алсын хараа-2050», «Шинэ сэргэлтийн бодлого» зэрэг бодлогын баримт бичигт чухлаар тавигдсан байна. Логистик менежментийн ахисан түвшний судалгаа сургалтын төв Монгол Улсын хөгжлийн зорилттой нийцэх бөгөөд олон улсын хөгжлийн чиг хандлагатай уялдсан шинэ хөтөлбөр амин чухал болоод байна.

Логистик менежментийн хөтөлбөрөөр Монгол Улсад бакалаврын түвшинд 3 их дээд сургууль хөтөлбөр хэрэгжүүлж байгаа байна. Үүнээс төрийн өмчит 2, хувийн хэвшлийн 1 их сургууль сургалтын үйл ажиллагаа явуулж байгаа боловч орчин үеийн олон улсын жишгээр ахисан түвшинд сургалтын хөтөлбөр хэрэгжүүлж байгаа сургалт үгүйлэгдэж байна. Тухайлбал, төр, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтын ажиллагаа хөгжүүлсэн, салбар дундын судалгаа шинжилгээг хийдэг, практик дадлага хийдэг, интерпрэнюр бизнесийн орчныг бойжуулах сайн хөтөлбөрүүд байхгүй байна.

Логистик менежментийн олон улсын жишиг сайн хөтөлбөрүүд МУИС-ийн харилцаа холбоо бүхий сургууль, судалгааны төвүүдэд байгаа бөгөөд хамтын ажиллагааны хүрээнд үүнийг Монгол Улсад Их сургуулийн Ахисан түвшний сургуулийн хүрээнд шинэ туршлага болгон авч хэрэгжүүлэх боломжтой.

Логистик менежменттэй холбоотой олон салбарын сургуулийн оюутнуудаас авсан санал асуулгын судалгааны үр дүнгээс үзэхэд энэ чиглэлээр ахисан

түвшний хөтөлбөрт суралцах хүсэл сонирхол өндөр байна. Ойрын 10 жилийн хугацаанд сургалтын хөтөлбөрийн олон талын мэргэшлийн хүрээнд Монгол Улсын эрэлт хэрэгцээ өндөр байхаар байна. Зөвхөн өнөөдрийн оюутны санал асуулгын дүнгээс үзэхэд энэ талаар эмпирик судалгаанд оролцсон оюутнуудын 74.3 хувь нь логистик менежментийн ахисан түвшний сургалтад хамрагдана гэжээ.

Ном зүй

1. Legalinfo.mn. (2020). Legalinfo.mn. УИХ (хууд. 212). Улаанбаатар: УИХ.
2. Mongolia, 2. К. (2020). [https://mrt.d.gov.mn/up/news/Auto_teever/ %D0%9B%D0%BE%D0%B3%D0%B8%D1%81%D1%82%D0%B8%D0%BA%D0%B8%D0%B8%CC%86%D0%BD%20%D1%82%D3%A9%D1%81%D3%A9%D0%BB.%20KSP%20Korea.pdf](https://mrt.d.gov.mn/up/news/Auto_teever/%D0%9B%D0%BE%D0%B3%D0%B8%D1%81%D1%82%D0%B8%D0%BA%D0%B8%D0%B8%CC%86%D0%BD%20%D1%82%D3%A9%D1%81%D3%A9%D0%BB.%20KSP%20Korea.pdf). Улаанбаатар: KSP Mongolia .
3. Mongolia, К. (2021). Монгол улсад ухаалаг логистик, тээврийг хөгжүүлэх, стратеги 2020/21 KSP Mongolia. Улаанбаатар: Mongolia, KSP.
4. Singapore, N. U. (2023 оны 07 5-17). TLI-AP (The Logistics Institute– Asia Pacific). <https://www.tliap.nus.edu.sg/>: <https://www.tliap.nus.edu.sg/wp-content/uploads/2023/04/LI5203-Summer-School-June-2023.pdf>-ээс Гаргасан
5. Techology, M. i. (2021 оны 06 30). <https://ctl.mit.edu/education/masters-programs>. Massachusetts instute of Techology: <https://ctl.mit.edu/education/masters-programs-ээс> Гаргасан
6. УИХ. (2020). Монгол Улсын хөгжлийн бодлого, алсын хараа 2050 хөтөлбөр. Улаанбаатар: УИХ.
7. ХХК, Г. с. (2019 оны 10 25). <http://www.mnline.mn/post/32340>. <http://www.mnline.mn/post/>: <http://www.mnline.mn/post/32340>

Нийтлэлийг 2023 оны 11-р сарын 20-ны өдөр редактор хүлээн авсан; хянан үзээд 2023.12.04-ны өдөр баталсан; 2023.08.12-нд хэвлүүлэхээр хүлээн зөвшөөрсөн.

SOME ISSUES OF LOGISTICS MANAGEMENT PROGRAM DEVELOPMENT BASED ON SOCIOLOGICAL RESEARCH

Urjinsuren Jargal

Ph. D.

urjinsuren@num.edu.mn

Bolormaa Jambaa

Master

bolormaa.j@num.edu.mn

Khongorzul Davaa

Ph. D.

khongorzul_d@num.edu.mn

Sarantuya Baatar

Master

sarantuya.b@num.edu.mn

Munkhbat Norovjamts
Master
munkhbat.n@num.edu.mn

Bat-Orshikh Altangerel
Master
batorshikh.a@num.edu.mn

National University of Mongolia
1 Ikh Surguuliyn St., Ulaanbaatar 14201, Mongolia

Abstract. According to the long-term development plan, Mongolia by 2050 should "become a nation with sustainable economic growth, a predominant middle class which will substantially reduce poverty, a solid economic development policy meeting domestic needs, increased exports, enhanced capacity in investment and savings, and a multi-pillar economy". This study program purpose is to prepare competent managers with scientific thinking, personal development and communication skills, capable of working independently in the fields of science, manufacturing, technology, transport and society according to the standards of developed countries.

Keywords: logistics, transport industry, economy, global transport, demand, long term development program.

For citation

Urjinsuren J., Bolormaa J., Khongorzul D. et al. Some Issues of Logistics Management Program Development Based on Sociological Research. *Oriental Vector: History, Society, State*. 2023; 4: 26–40 (In Mong.).

The article was submitted 20.11.2023; approved after reviewing 04.12.2023; accepted for publication 08.12.2023.